КВАНГЖУ ХОТЫН ИРГЭДЭД ӨДӨР ТУТМЫН ХЭВИЙН АМЬДРАЛД ЭРГЭН ОРОХОД ТУСЛАМЖ БОЛГОН ОЛГОЖ БАЙГАА ТЭТГЭМЖ (Гадаад иргэнд зориулсан хувилбар)

Хэнд зориулан олгох	Квангжу хотод бүртгэлтэй оршин сууж байгаа гадаад иргэд болон гадаад иргэний үнэмлэх бүхий солонгос иргэд (2021 оны 12 дугаар сарын 1-ний 24:00 цагийн байдлаар). ※ Нярай хүүхдийн хувьд, эцэг, эхийн аль нэг нь 2021 оны 12 дугаар сарын 1-ний 24:00 цагийн байдлаар тэтгэмж авах эрхтэй бөгөөд хүүхдийн төрсний гэрчилгээ эсвэл төрөх тухай мэдээллийг өргөдөл авах хугацаа дуусахаас өмнө бүрдүүлэн өгсөн тохиолдолд тэтгэмж авах боломжтой.
Тэтгэмжийн хэмжээ	Хүн тус бүрт 100,000 вон
Тэтгэмж олгох хэлбэр	Урьдчилсан төлбөрт тэтгэмжийн картыг (상생카드) тухайн хүсэлт гаргаж байгаа байранд хэвлэж өгнө.

Бүртгүүлэх хугацаа	2022 оны 1 дүгээр сарын 17 (Даваа гараг) –2022 оны 2 дугаар сарын 28 (Даваа гараг)
Эхний долоо хоног	* Эхний долоо хоногт таван бүлэгт хуваарилж бүртгэлийг тохирох өдөр нь хийнэ. (1 дүгээр сарын 17-21) Төрсөн оны сүүлийн тоог үндэслэн хуваарийн дагуу бүртгэнэ.

1 сарын 17 (Даваа)	1 сарын 18 (Мягмар)	1 сарын 19 (Лхагва)	1 сарын 20 (Пүрэв)	1 сарын 21 (Баасан)
1, 6	2, 7	3, 8	4, 9	5, 0

Ажиллах цаг	Ажлын өдрүүд 09:00-18:00
Хүсэлт гаргах хэлбэр	* 2021 оны 12 дугаар сарын 1-ний 24:00 цагийн байдлаар албан ёсны бүртгэлтэй байгаа иргэд оршин сууж байгаа харьяа дүүргийн захиргаанд (행정복지센터) очиж бүртгүүлнэ. * Өргөдлийн маягтын хамт бичиг баримтаа авчирна. - Бичиг баримт (аль нэгийг сонгох): Гадаад иргэний үнэмлэх, гадаад иргэний үнэмлэхийг батлах гэрчилгээ, байнгын оршин суух карт, иргэний бүртгэлийн карт * Бусдын өмнөөс өргөдөл гаргаж байгаа тохиолдолд өргөдөл гаргагчийн бичиг баримт, тухайн иргэний өмнөөс өргөдөл гаргаж байгаа хүний бичиг баримт, төрөл садангийн тодорхойлолт, итгэмжлэгдсэн төлөөлөгч болохыг тодорхойлсон бичиг зэргийг хавсаргана.
Бусдын өмнөөс өргөдөл гаргах	* Бусдын өмнөөс өргөдөл гаргаж болох хүмүүс: Эхнэр/нөхөр, цусан төрлийн холбоотой хүмүүс, цусан төрлийн холбоотой хүний гэр бүл, ах, эгч дүүс. *Бага насны хүүхэд (2002 оны 12 дугаар сарын 2-ны өдрөөс хойш төрсөн): Хуульч ёсны төлөөлөгч

Бусад мэдээлэл	Зөвхөн Квангжү банкинд (гарын үсэг зурж) карт эзэмшигчээр бүртгүүлсэн тохиолдолд, татвараас чөлөөлөгдөх болон карт дахин хэвлэн авах эрхийг олгоно. <Дансны үлдэгдэл шалгах> - Квангжү банкны хэрэглэгчийн төв (☎1577-3650): Энэ дугаар луу утасдаж дараа нь 832 гэж залган үлдэгдлийг шалгана. - Карт ашигласан тохиолдолд, баримтын доорх хэсэгт үлдэгдлийг шалгах боломжтой. (Үйлчлүүлсэн дэлгүүрээс шалтгаалан үлдэгдэл харагдахгүй байх боломжтой.) <Картыг гээсэн болон гэмтсэн тохиолдолд дахин хэвлэх> - Картыг дахин хэвлэхэд заавалчгүй (гарын үсэг зурж) карт эзэмшигчээр бүртгүүлсэн байх шаардлагатай. - Карт эзэмшигч Квангжү банкинд биеэр очих ёстой. <Карт эзэмшигчээр бүртгүүлэх дараалал> - Квангжү банкны интернэт банк (www.kjbank.com): Үндсэн цэс-> Хувийн банк -> Карт -> Бэлгийн карт -> Хэрэглэгчийн бүртгэл - Квангжү банкны хэрэглэгчийн төв (☎1577-3650): Энэ дугаар луу залгаж 831 дээр даран бүртгүүлнэ.
Хүчинтэй хугацаа	2022 оны 5 дугаар сарын 31 хүртэл
Хэрэглэх газар	Зөвхөн Квангжү хотод ашиглаж болно.
Ашиглах хязгаарлалт	Их дэлгүүр, худалдааны төв, супермаркет, үзвэр үйлчилгээний газар, татвар төлөх, ус цахилгааны мөнгө, орон сууцны төлбөр, нийтийн тээврийн хэрэгслийн зардал (галт тэрэг, автобус, такси, нислэг), цахим худалдаа, цахим гүйлгээ, хүргэлтийн аппликеишн (“Wemakeprice” аппликэйшнд ашиглах боломжтой), гэх зэрэг.

Лавлагаа

Өрхийн бүртгэлд ороогүй боловч бусдын өмнөөс өргөдөл гаргах эрх бүхий хүн, түүний бүрдүүлэх шаардлагатай бичиг баримт

* (Бусдын өмнөөс өргөдөл гаргах) Тухайн хүн өөрөө эсвэл албан ёсны гэр бүлийн бүртгэлд байгаа хүн өргөдөл гаргах ёстой. Хэдий тийм боловч доор дурдсан тохиолдолд бусдын өмнөөс өргөдлийг хууль ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгч эсвэл садан төрлийн холбоотой хүн гаргаж болно.

Ангилал	Бусдын өмнөөс өргөдөл гаргах эрх бүхий хүн	Шаардлагатай бичиг баримт				Нэмэлт тайлбар
		Бусдын өмнөөс өргөдөл гаргаж байгаа хүний бичиг баримт	Өргөдөл гаргах чийн бичиг баримт	Хууль ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгч болохыг батлсан бичиг	Ямар холбоотойг нотлосон бичиг баримт	
① Хөдөлгөөний бэрх шээлтэй, асрах газар, эмнэлэг зэрэгт байгаа иргэн мөн өндөр настай иргэн ※ Өөрөө бие даан шийдвэр гаргах чадваргүй хүний тухайд ⑤ хэсгийг харна уу	Эхнэр/нөхөр, цусан төрлийн холбоотой хүмүүс, цусан төрлийн холбоотой хүний гэр бүл, ах, эгч дүүс	◦	◦	◦	◦	
②Насанд хүрээгүй хүүхэд	Хууль ёсны төлөөлөгч	◦			◦	
③Цэргийн алба	Эхнэр/нөхөр, цусан төрлийн холбоотой хүмүүс, цусан төрлийн холбоотой хүний гэр бүл, ах, эгч дүүс	◦			◦	(Нэмэлтээр шаардах бичиг баримт) Цэрэгт татагдсан баталгаа
④ Гадаад улсад амьдарч байгаа		◦		◦	◦	(Нэмэлтээр шаардах бичиг баримт) Цагаачлалын албанаас хилээр гарсан бүртгэлийн хуулбарыг авчрах
⑤ Бие даан шийдвэр гаргах чадамжгүй		◦			◦	(Нэмэлтээр шаардах бичиг баримт) Бие даан шийдвэр гаргаж чадахгүй болохыг нотолсон эмчийн тодорхойлолт зэрэг
⑥ Засан хүмүүжүүлэх газар	Эхнэр/нөхөр, цусан төрлийн холбоотой хүмүүс, цусан төрлийн холбоотой хүний гэр бүл, ах, эгч дүүс	◦			◦	(Нэмэлтээр шаардах бичиг баримт) Тухайн газар орсон болохыг гэрчилсэн тодорхойлолт

	Хэрэв тухайн хүн өөрөө хүсэлт гаргаваал тухайн байгуулагын дарга өмнөөс нь өргөдөл гаргаж тэтгэмж авах болно.					Тухай байгууллагын дарга тэтгэмж авах хүсэлт гаргасан бүх хүний жагсаалтын гарган албан бичиг ирүүлж болно.
⑦Хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч	Хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч ийг хамгаалах төвийн дарга (тухайн хохирогч хүсэлт гаргасан тохиолдолд)	◦ (Төвийн дарга)		◦	◦ (Эрх бүхий албан тушаалтан мөн эсэхийг тодорхойлсон бичиг баримт)	(Нэмэлтээр шаардах бичиг баримт) Тухайн төвд байгааг тодорхойлсон албан бичиг
⑧Өргөж авах гэж байгаа үүхэд, асрах газар амьдарч байгаа хүүхэд, дагавр хүүхэд зэрэг	Албан ёсны бүртгэлтэй асрах төвийн дарга эсвэл хүүхэд асрагч	◦			◦ (Нэмэл мэдээлэл хэс гээс үзнэ үү.)	*(Өргөж авах гэж байгаа хүүхэд) Хүүхдийг ямар хүн өргөж авах гэж байгаа тухай баталсан албан ёсны тодорхойлолт болон тухайн хүүхэд асрамжын газарт байгаа эсэхийг тодорхойлсон бичиг *(Асрах газар амьдарч байгаа хүүхэд , дагавар хүүхэд зэрэг) Асрах газрын эсвэл албан ёсны агентлагийн албан бичиг

⑦ Гадаад иргэдтэй холбоотой түгээмэл гардаг асуулт

7-1	Өдөр тутмын хэвийн амьдралд эргэн ороход тусламж болгон олгож байгаа тэтгэмжийг ямар хүмүүс авч болох вэ?

❍ Квангжу хотод бүртгэлтэй оршин сууж байгаа гадаад иргэд болон гадаад иргэний үнэмлэх бүхий солонгос иргэд (2021 оны 12 дугаар сарын 1-ний 24:00 цагийн байдлаар).

7-2	Өдөр тутмын хэвийн амьдралд эргэн ороход тусламж болгон олгож байгаа тэтгэмжийг гадаад иргэдэд төлбөрийн ямар хэлбэрээр олгох вэ?

❍ Урьдчилсан төлбөрт тэтгэмжийн карт (상생카드) захиалахын тулд гадаад иргэд дүүргийн захиргааны төв (행정복지센터) дээр очих ёстой.

7-3	Бүртгэлийн үед төрсөн гадаад иргэний хүүхэд тэтгэмж авах боломжтой юу?

❍ Энд солонгос үндэстэнтэй адил журам үйлчилнэ. 2021 оны 12 дугаар сарын 1-ний өдөр хүртэл төрсөн хүүхдийн мөн энэ үед эхийн хэвлийд байгаа хүүхдийн эцэг, эхийн аль нэг нь тэтгэмж авах эрхтэй бөгөөд хүүхдийн төрсний гэрчилгээ эсвэл төрөх тухай мэдээллийг өргөдөл авах хугацаа дуусахаас өмнө (2022 оны 2 дугаар сарын 28) бүрдүүлэн өгсөн тохиолдолд тэтгэмж авах боломжтой.

7-4	Таван бүлэгт хувааж хийх бүртгэлд гадаад иргэд бас хамрагдах уу?

❍ Таван бүлэгт хувааж хийх бүртгэлд гадаад иргэд бас хамрагдана.

❍ Гадаад иргэний үнэмлэхний эсвэл оршин суух бүртгэлийн (гадаад үндэстний бүртгэлтэй солонгос үндэстэн) эхний 2 тоо таны төрсөн оны сүүлийн хоёр тоог илэрхийлж байдаг бөгөөд энэ нь солонгос иргэний бүртгэлийн дугаарын системтэй ижил бүтэцтэй.

(Жишээ) Гадаад иргэний бүртгэлийн дугаар 123456-456899
⇒ (2) гэсэн тоо таны төрсөн оны сүүлийн тоог зааж байна. Тийм болохоор та 2 дахь өдөр буюу Мягмар гаргат бүртгүүлнэ.

1 сарын 17 (Даваа)	1 сарын 18 (Мягмар)	1 сарын 19 (Лхагва)	1 сарын 20 (Пүрэв)	1 сарын 21 (Баасан)
1, 6	2, 7	3, 8	4, 9	5, 0

7-5	Гадаад иргэний өмнөөс хэн өргөдөл гаргаж болох вэ?

❍ Бусдын өмнөөс өргөдөл гаргах эрх бүхий хүмүүс нь гэрлэлтийн баталгаатай эсвэл ураг төрлийн холбоотой, эсвэл эрүүл мэндийн даатгалын гэрчилгээн дээр гэр бүлийн гишүүн гэж бичигдсэн байна.

7-6	Хэрвээ тэтгэмж авах эрх бүхий эцэг эх болон насанд хүрээгүй хүүхэд дүүргийн захиргаан дээр гадаад иргэний үнэмлэх, эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ эсвэл гэр бүлийн холбоотой болохыг тодорхойлсон өөрийн улсын ямар нэгэн бичиг баримт авчраагүй бол энэ тохиолдолд асуудлыг яаж шийдэх вэ?

❍ Хэрвээ ураг төрлийн холбоотой болохыг баталсан ямар нэгэн бичиг баримт авчраагүй бол тэтгэмж авахын тулд доор заасан 2 болзлыг биелүүлсэн байх шаардлагатай. Үүнд:

①Тэтгэмж авах эрх бүхий эцэг эх болон бага насны хүүхэд дүүргийн захиргааны төв дээр хамт очиж бичиг баримтаа үзүүлнэ. (Бага насны хүүхэд өөрийн гадаад иргэний үнэмлэхийг үзүүлнэ.)

② Эцэг эх болон бага насны хүүхдийн ижил бүртгэл бүхий оршин сууж байгаа газрын бүртгэлийг үзүүлнэ.

7-7	Албан ёсны оршин суух хугацаа нь дууссан хүн тэтгэмж авахаар өргөдөл гаргаж болох уу?

❍ 2021 оны 12 дугаар сарын 1-ний байдлаар бүртгэлтэй байсан бөгөөд тэдний визний хугацаа 2 дугаар сарын 14-ны өдөр дуусч байгаа бол энэ өдрөөс өмнө эсвэл 14-ны өдөр тухайн гадаад иргэн өргөдөл гаргаж болно.

❍ Өргөдөл гаргах өдрөөс өмнө тухайн хүний визний хугацаа дууссан бол тэр хүнийг бүртгэлгүй иргэн гэж үзэх бөгөөд тэтгэмж авах эрх үүсэхгүй.

7-8	Хууль бусаар оршин сууж байгаа гадаад иргэдийн тухайд ямар шийдвэр байгаа вэ?

❍ Цагаачлалын хяналтын хуулийн дагуу хууль бусаар оршин сууж байгаа гадаадын иргэдийг хууль бус оршин суугч гэж үздэг тул тэтгэмж авах өргөдөл гаргах боломжгүй.

7-9	2021 оны 12 дугаар сарын 1-ний өдөр гадаад иргэний бүртгэлтэй байсан боловч визний хугацааг сунгаагүй бөгөөд COVID-19-ийн улмаас түр оршин сууж байгаа тохиолдолд (өөрөр хэлбэл, гадаад иргэний үнэмлэхээ буцааж өгсөн) тэтгэмж авах өргөдөл гаргах боломжтой юу?

❍ Тухайн улсаас явах нислэг байхгүй зэрэг зайлшгүй үүссэн нөхцөл байдлаас болж тухайн оронд түр оршин суухыг зөвшөөрдөг. Албан ёсоор бол энэ хүнийг бүртгэлтэй гадаад иргэн гэж үздэггүй.

❍ Энэ тэтгэмжийг Квангжү хотод оршин суудаг албан ёсны бүртгэлтэй гадаад иргэн эсвэл гадаад иргэний үнэмлэхтэй солонгос үндэстэнд олгох заалттай тул визний хугацааг сунгаагүй COVID-19-ийн улмаас түр оршин сууж байгаа иргэдэдтэтгэмж олгох боломжгүй.

7-10	Тэтгэмж авах эрхтэй боловч түр зуур гадаадад байгаа хүн өргөдөл гаргаж болох уу?

❍ Тухайн хүн түр зуур гадаадад байгаа бөгөөд өөрийн биеэр өргөдөл гаргаж чадахгүй тул Солонгост байгаа шаардлага хангасан бичиг баримттай гэр бүлийн гишүүн өмнөөс нь өргөдөл өгч болно. Хэрэв тухайн өргөдлийг өргөдөл авах хугацааны дотор гаргахгүй бол тэтгэмжийг олгох боломжгүй.